

"Экологийн боловсролд суурилсан Эко сургууль"

төсөл

Монгол Улсын Их Сургуулийн Экологийн Боловсролын Төвөөс Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" хөтөлбөр, Галсан Чинаг сангийн захиалгаар "Экологийн боловсролд суурилсан Эко сургууль" төслийг 2013 оны 7-12 сарын хооронд хэрэгжүүлэв. Энэхүү төслийн зорилго нь нийслэлийн гэр хорооллын дунд байрлах нэг ЕБС-ийг сонгон авч эко сургуулийн 7 алхмыг хэрэгжүүлэх, тухайн сургуулийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, сургуулийн гадаад, дотоод орчны эко байдлыг сайжруулах зэрэг байв.

Бид төслийг хэрэгжүүлэх сургуулийг сонгохдоо боломжит сургуулиудын гадаад, дотоод орчны ерөнхий байдлыг шинжиж, захирал, удирдлагатай нь уулзан, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, байгалийн ухааны багш нарын төслийг хамтран хэрэгжүүлэх сонирхол, идэвх зүтгэл ямар байгаа зэргийг тандсан бөгөөд уг судалгааг үндэслэн нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16-р сургуулийг хамгийн тохиромжтой сургууль гэж сонгон авсан болно.

Бид төслийг урьдчилан боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь амжилттай гүйцэтгэж дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

1. Эко сургууль болох 7 алхмыг хэрэгжүүлэх: Эко сургууль хөтөлбөр нь олон улсын хөтөлбөр бөгөөд байгаль орчныг хамгаалах болон амьдрах, сурах орчноо аятай, эрүүл, хүүхдэд болон байгальд ээлтэй байлгахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилготой юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж, байгальд ээлтэй болохын тулд сургууль 7 алхмыг хийж гүйцэтгэх ёстой. Бид энэхүү төслийн хүрээнд юуны өмнө энэхүү 7 алхам нь юу болох, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай 5-аас дээш ангийн бүх сурагчдад мэдээлэл өгч, эко зөвлөлийн гишүүн болж өөрийн ирээдүйн төлөө идэвхтэй хамтран ажиллахыг уриалсан сургалт явууллаа. Үүний дараа сайн дураараа, санаачлагаараа Эко зөвлөлийн гишүүн болсон сурагчдад нарийн, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, сургуулийн болон анги танхимыхаа гадаад, дотоод орчныг үнэлэхэд туслах

зорилго бүхий хоёр дахь удаагийн сургалтыг явуулсан болно. Энэ сургалт, мэдээллийн ажлаас гадна төсөл хэрэгжих явцад Эко зөвлөлийн гишүүд, сургуулийн хамт олонд аргазүйн зөвлөгөө байнга өгч ажиллав. Мөн Эко зөвлөлийн үйл ажиллагааг идэвхтэй, үр дүнтэй байлгах, хүүхдүүдийг чиглүүлэх, үйл ажиллагаа явуулахад нь туршлага олгох зорилгоор, нөгөө талаас залуусыг нийгмийн амьдралд оролцож, туршлага хуримтлуулах боломж олгох үүднээс МУИС-ийг байгалийн ухааны чиглэлээр төгссөн, "Ногоон давалгаа" клубын гишүүн Ж.Гандолгор, Г.Халиун нарыг ажиллуулав. Ж.Гандолгор, Г.Халиун нар маш сайн ажиллаж, хүүхдүүдийн дунд олон арга хэмжээ зохион байгуулж, Эко зөвлөлийг хойшид бие даан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсийг нь тавьж өгсөн юм.

2. Сургуулийн эко стандартыг нэмэгдүүлэх, эко анги тохижуулах, сургуулийн гадаад, дотоод орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. Аливаа сургууль, албан байгууллага байгальд ээлтэй болохын тулд гадаад, дотоод орчиндоо мод, цэцэг тарих, арчлан ургуулахаас гадна ус, тог цахилгаан, халаалт хэмнэх арга хэмжээ авах шаардлагатай. Хамгийн гол нь сургуулийн орчин хүүхдүүдэд болон сургуульд ажиллагсад эрүүл, таатай орчин болох ёстой. Эко сургууль болох 7 алхамд ч энэ томоохон байр суурийг эзлэдэг. Гэвч эко сургууль болох гэж буй ихэнх сургуулиудын хувьд орчиндоо үнэлгээ хийгээд, үнэлгээндээ үндэслэн болохгүй, дутагдалтай зүйлсээ сайжруулъя гэтэл хөрөнгө мөнгөний асуудал гарч ирж, гацах байдалд орох нь элбэг. Энэ асуудлыг шийдэхэд туслах зорилгоор төслийн зүгээс тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлж, нэг ангийг эко анги болгох, сургууль өөрөө байгальд ээлтэй, байгалийн нөөцөд хэмнэлттэй үйлдэл хийх бололцоог олгов. Энэ ажлын хүрээнд сургуулийн 206 дугаарын өрөөний ханыг засан сайжруулж, сайн чанарын, хоргүй будгаар будуулан янзлуулж, шалыг нь бүрэн солиулав. Мөн цонх, хаалганы дулаан алдалтыг багасгах зорилгоор хаалгыг шинэчилж, хагарсан шилтэй цонхыг шиллүүлэв. Ангид модон тавиур, хувцасны өлгүүр хийлгэн, хог ялгаж хаях сав, мэдээллийн самбар зэргийг байрлууллаа. Тэрчлэн сургуулийн эко стандартыг сайжруулах зорилгоор гуравдугаар давхрын 4 ширхэг модон цонхыг вакум цонхоор сольж, нэг давхрын дулаан хамгийн ихээр алддаг хаалгыг сайн чанарын модон хаалгаар солилоо. Цаашилбал сургуулийн зүүн өмнөх талбайд цэцэрлэгжүүлэлт, гоёл чимэглэлийн 10 зүйлийн 200 гаруй мод тарьж хаягжуулав. Мод тарих ажилд 7, 11-р ангийн сурагчдыг оролцуулсны дээр шаардлагатай багаж хэрэгслийг сургуульд хүлээлгэн өгсөн юм. Мөн сургуульд навчаараа болон

цэцгээрээ гоёдог 15 ширхэг тасалгааны цэцгийг арчлах зааврын хамт өглөө. Сургуулийн гадна 600 м² талбайд зүлэгжүүлэлт хийж, 27 м² талбайд мандлын цэцэг тарив.

3. Сурагчдад экологийн боловсрол олгох: Эко сургууль болох 7 алхмыг сургууль болгон өөр өөрийн бололцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагааны хамгийн гол хэсэг нь сурагчдад байгаль орчиндоо ээлтэй байх зарчмуудыг сургах, яагаад байгалиа хайрлах хэрэгтэй болохыг ойлгуулах, орчноо хамгаалахын тулд одооноос, өөрөөсөө хэрхэн эхлэх тухай зааж сургах явдал юм. Бидний энэ удаагийн үйл ажиллагааны хамгийн гол зорилго нь ч экологийн боловсрол олгох байв. Бид энэ ажлын хүрээнд сургуулийн 5-аас дээш ангийн бүх хүүхдэд Экологийн ул мөр, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг агуулгыг багтаасан сургалт явуулсан юм. Энэ сургалтаар хүүхэд бүхэн энгийн өдөр тутмын ямар үйлдлийг өөрөө хийж хэвших хэрэгтэйг, мөн бидний хаа сайгүй хаясан хог өч төчнөөн жилээр байгальд задралгүй хэвтэж байдаг, ийм байлгахгүйн тулд яах ёстой талаар ярилцсан нь хүүхдүүдийн сонирхлыг их татав. Мөн мод тарих, арчлах хичээлийг сургуулийн бүх хүүхдэд зориулан явууллаа. Ингэхдээ өөрсдийн боловсруулсан “Яагаад мод тарих хэрэгтэй вэ”, “Мод, сөөгийг яаж таньдаг юм бол”, “Мод тарихын өмнө юуг бэлдсэн байх вэ”, “Мод тарья, гэвч яаж”, “Мод тарьсны дараа” гэсэн хэсгүүдээс бүрдсэн дүрсжүүлсэн хичээлийг ашиглав. Үүнээс гадна сургуулийн коридорт хог задрах хугацааг харуулсан самбар байрлуулж, “Хогийг ангилах”, “Цөлжилт” сэдэвт мэдээллийн эвхмэл боловсруулж хэвлүүлэн тараав. Төслийн гол үр дүнгүүдийн нэг нь бид мод тарих, арчлах тухай “Модонд амьдрал, өөртөө агаар” хүүхэд, олон нийтэд зориулсан гарын авлага боловсруулж хэвлүүлсэн явдал байлаа. Экологийн боловсрол олгох ажлын хүрээнд бид сургуулийн бүх сурагчдыг төвийн танин мэдэхүйн өртөөчилсэн сургалтанд хамрууллаа. Хүн, байгалийн шүтэлцээ, байгаль дээрх бүх амьд организмын хоорондын холбоо хамаарлын тухай сонирхолтой хэлбэрээр, насны онцлогт нь тохируулсан агуулгаар явуулсан уг сургалтын зорилго нь байгалийг танин мэдэх, хайрлах эрмэлзэл төрүүлэх байв. Уг сургалтыг бид төвийн хүлэмж, музей, цэцэрлэгт хүрээлэн зэрэг сургалтын амьд орчинд түшиглэн зохион байгуулав. Сурагчдад зориулсан эдгээр сургалт, арга хэмжээнээс гадна бид багш нарт зориулж байгаль орчны сэдвийг төрөл бүрийн хичээлийн агуулгад тусгах талаар болон байгаль хамгааллын орчин үеийн чиг хандлагын талаар тусгайлан сургалт явууллаа.

Бид төсөл хэрэгжихийн өмнө болон дараа 8-р ангийн бүх сурагчдаас экологийн мэдлэгийг үнэлэх тест, 7-р ангийн бүх сурагчдаас мод тарих, арчлах тестийг авч дүгнэлээ. Үнэлгээгээр сурагчдын экологийн мэдлэг 1114 онооноос (авах ёстой 100 хувиас 18 хувь) 3916 оноо болж (авах ёстой 100 хувиас 62 хувь) 3,5 дахин нэмэгдсэн бол мод тарих, арчлах тухай мэдлэг нь 48-65% болж 16%-аар өсжээ.

Аливаа ажлыг амжилттай зохион байгуулахад хамтран ажиллагч байгууллагын идэвх, сонирхол маш чухал байдаг. Ялангуяа сургуулийн бүх хүүхдийг хамруулсан сургалт зохион байгуулах, тарьсан мод, орчныг арчлах, байнга харж хамгаалах ажлаас төслийн үр дүн ихээхэн шалтгаалдаг болохыг бид мэдэх билээ. Бидний үйл ажиллагааг дэмжин, Монголын хүүхэд багачуудад оюуны хөрөнгө оруулалт хийсэн Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Биологийн олон янз байдал ба ойн гол экосистемүүдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь" хөтөлбөр, Галсан Чинаг сангийн хамт олон, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, идэвхтэй, үр дүнтэй хамтран ажилласан 16-р сургуулийн захирал Л.Амартуяа, нийгмийн ажилтан С.Энхтайван, түүх, газарзүйн багш Х.Ганхүү болон "Эко элч" эко зөвлөлийнхөнд баярласан талархсанаа илэрхийлж байна.

Хавсралт


Зүлэгжүүлэлт, мандлын цэцэг



Хэвлүүлсэн эвхмэлийг хүлээлгэн өгч байгаа нь



Өртөөчилсөн сургалтын хуваарь



Манай өртөөчилсөн сургалтаар үйлчлүүлсэн 16-р сургуулийн хүүхдүүд





“Мод тарих, арчлах” сургалтын материалаас

Модтой газрын агаар цэвэрхэн байна.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Мод орчныг гоёмсог харагдуулна.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Бид мод, сөөгний үр жимсэнд дуртай.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Мод сүүдэр үүсгэнэ.
Салхийг хаана.
Бас агаарыг чийгшүүлдэг.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Хашаагаа олон зүйлийн модоор чимбэл сайхан харагдана.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Модыг хэлбэржүүлж, тохилог орчин бүрдүүлж болно.



1. Мод бидэнд хэрэгтэй юу?



Мод, сөөгийг навчит мод, шилмүүст мод гэж 2 ангилна.

Навч Шилмүүс

Хус, улиас бол навчит мод юм. Харин шинэс, гацуур бол шилмүүст мод.

2. Модыг ааж таныдаг юм бол?

Мод Сөөг

Нэг гол иштэй, өндөр ургадаг бол мод гэнэ. Ижил хэмжээний олон иштэй, иш нь дороос салаалж эхэлсэн бол сөөг юм. 5 метр хүртэл

2. Модыг ааж таныдаг юм бол?

Гацуур

Шилмүүс нь нэг дороос нэг нэгээр гарна. Боргоцой зууван

3. Эврим модны онцлог

Хуш (самарны мод)

- Үр жимс нь бидний иддэг самар юм.
- Шилмүүс нь нэг дороос таван ширхэгээр гарна.

3. Эврим модны онцлог

Хус

Холтос нь цагаан Навч нь ромборхуу

3. Эврим модны онцлог

Улиас

Эр цэцэг Эм цэцэг Үр жимс

- Хотын гудамжинд хамгийн их тарьдаг.
- Эр, эм модыг цэцгээр нь ялгаж болно.
- Үр нь хөвөн шиг хийснэ.

3. Эврим модны онцлог

Тарих үед навч шилмүүсгүй байвч, хэдхэн сарын дараа ургаж эхэлнэ.

Намар тариу үед... Хавар

4. Модыг аягад хайрлах хэрэгтэй ээ?

Амьгүй, гадас мэт харагдавч, хавар болоход ургаж цэцэглэнэ.

Тарих үед... 1 сарын дараа

4. Модыг аягад хайрлах хэрэгтэй ээ?

Хоёрдогч түүхий эд цуглуулж тушаах арга хэмжээний үеэр



Мод тарих өдөр








Сургууль тасалгааны цэцгээ 14 зүйл цэцгээр баяжуулав.





11д - эко ангийн төсөл хэрэгжихийн өмнөх болон дараах байдал







“Экологийн үл мөр, хог хаягдал” сургалтын материалаас

<p>ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ</p> <p>Үүнийг задлахад хэр их хугацаа орох бол?</p> <p>ХОГ БАЙГАЛД ШИНГЭХ ХУГАЦАА</p>	<p>ӨНДӨГНИЙ ХАЛЬС</p> <p>30</p> <p>ХОНОГ</p> <p>ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ</p>
<p>ХУВАНЦАР САВ</p> <p>450</p> <p>ЖИЛ</p> <p>ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ</p>	<p>ШИЛЭН ЛОНХ</p> <p>1-2</p> <p>САЯ ЖИЛ</p> <p>ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ</p>

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

Экологийн үл мөрөө яаж багасгах вэ?

ХҮН БҮР ХИЧЭЭЭ!





ТОГОО ХЭМНЭЭ!

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ






УСАА ХЭМНЭЭ!

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ





ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ

Хэрэглээгээ багасгая!
Эргүүлэн ашиглая!
Дахин боловсруулъя!

ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭЭ!





Сургуулийн эко стандартыг сайжруулсан нь





Экологийн боловсрол олгох сургалтын явц



Багш нарт зориулсан сургалт



Эко зөвлөлөөс эцэг эхчүүдэд зориулж зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөр



Төслийн үр дүнд Др.Р.Сүнжидмаагийн эмхэтгэсэн “Модонд амьдрал, өөртөө агаар” хүүхэд, олон нийтэд зориулсан танин мэдэхүйн гарын авлага хэвлэгдэн гарав.



МУИС-ийн Экологийн боловсролын төв
2013 оны 12 сар